

Нэг. НИЙСЛЭЛИЙН ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

1925 оны 12 дугаар сарын 11-нд “Улаанбаатар хотын захиргааны дагаж мөрдөх дүрэм”-ийг баталсны дагуу Хотын ариутгах засах хэлтсээс түүхээ эхэлсэн өнөөгийн Нийслэлийн хот тохижилтын газар юм. Хотын ариутгах засах хэлтэс нь хотын доторхи хог шороог цэвэрлэх, ариун цэврийг нийт ард иргэдэд сахиулах, мод тарих, бие засах газрыг журамтай болгох, хашаа байшин барих, газар олгох, шилжүүлэх, хашаа байшинд дугаар олгох, нүүлгэх, мал нядлах, худаг малтах зэрэг асуудлыг эрхлэн гүйцэтгэж байсан.

1958 оны 04-р сарын 01-нд Сайд нарын Зөвлөлийн хурлаар хот сайжруулах комиссын төслийг баталж, Хот тохижуулах хэлтсийг хот тохижуулах газар болгон өргөжүүлжээ.

1961 оны 11-р сарын 24-нд сайд нарын зөвлөлийн 601-р тогтоолоор Хот тохижуулах хэлтсийн Хот тохижуулах газар болгосон. 1964 оны эцэс гэхэд 634,0 мянган ам метр талбайг цэцэрлэгжүүлж, 408,3 ширхэг мод бут тарьж ургуулж, нэг хүнд ноогдох цэцэрлэгжүүлсэн талбай 8,8 метр болсон байв. Тус газар нь хотын дэвсгэр нутгийн газар эдэлбэр, зам гүүр далан сувгийн ашиглалт, гудамж талбайн мод цэцгийг арчлан хамгаалах, гэрэлтүүлэг гэрлэн дохио, реклам чимэглэл, хөшөө дурсгалын засвар ашиглалт, хотын чимэглэл, хог тээвэрлэлтийн ажлыг хариуцан ажиллаж байлаа.

1973 онд хот тохижуулах газрын авто баазыг Хот цэцэрлэгжүүлэх газрын авто баазтай нэгтгэн Тусгай үйлчилгээний авто аж ахуй болгон зохион байгуулжээ. 1962-1993 онуудад зохион байгуулалтын хувьд аж ахуйн тооцоотой, зам далан сувгийн ашиглалтын контор, тусгай үйлчилгээний авто аж ахуйн, реклам чимэглэлийн үйлдвэр, цэцэг мод үржүүлэх арчлан хамгаалах аж ахуй, гэрэл цахилгааны тасаг, хиймэл цэцгийн үйлдвэрээс бүрдэж байв.

1995 онд Нийслэлийн захирагчийн ажлын алба байгуулагдан, хот тохижуулах газар нь тус газарт харьяалагдах болсон байна.

2006 оны 9-р сард Нийслэлийн Засаг даргын 445-р захирамж гарч Улаанбаатар хотын захирагчийн харьяанд Хот тохижилтын газрыг байгуулсан. 2007 онд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 107-р тогтоолоор “Нөөц” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгаж үйл ажиллагааг нь тус газарт шилжүүлсэн.

2012 онд Хот тохижилтын газрын дүрэм, бүтэц орон тоог шинээр боловсруулан Нийслэлийн Засаг даргын А/106 тоот захирамжаар батлуулсан. Тус газрын бүтэц:

- Газрын дарга
- Орлогч дарга гэсэн удирдлагатай
- Захиргаа, эдийн засаг, хүний нөөцийн алба

- Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн алба: Морин даваа, Цагаан даваа, Хог боловсруулах хатуу түлшний үйлдвэр
- Тохижилт үйлчилгээ, ногоон байгууламж
- Авто бааз гэсэн алба нэгжэйгээр орон тооны 285 ажилтан ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж баёсан.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- ✓ Хог хаягдлын чиглэлээр: хог тээвэрлэх, хог хаягдлыг ландфилл технологийн дагуу дарж булаах
- ✓ Гудамж талбайн тохижилтын чиглэлээр: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн тохижилтын ажил
- ✓ Золбин нохой муурын устгалыг хариуцан ажилладаг байсан.

Япон болон солонгосын улсын төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж дуусаж, БНСУ-ын Койка байгууллагын тусламжаар Нарангийн энгэрийн хогийн цэг дээр Хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулсан. 2012 онд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт 302883,59 тонн хог, Морин давааны төвлөрсөн хогийн цэгт 72195,49 тонн хог, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт 158621,09 тонн хог буюу нийт 533700,17 тонн ирснийг ландфилл технологийн дагуу дарж булсан байна. Золбин нохой муур 69334 ширхэгийг устгав. Хариуцсан гудамж талбай болон гэрээ байгуулан ажиллаж буй аж ахуй нэгжүүдийн хогийг тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэж, хог тээврийн машин техникүүдийн засвар үйлчилгээг цаг тухай бүр хийж ажиллав.

Тасганы овооны тохижилтын ажлыг тус оны 4 дүгээр сараас 8 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэн Чингэлтэй дүүргийн тамгын газарт хүлээлгэн өгсөн. Уг ажлын хүрээнд Тасганы овооны иж бүрэн тохижилтын 5 хэсэгчилсэн ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: уулын 10200 м² хог шороог цэвэрлэж, түүнээс гарсан хог хаягдлыг тээвэрлэх, уулын налууд 2950,16 м² буюу 18438,5 ш эко хавтан тавьж, 2200 м³ үерийн усны суваг шуудуу гаргаж, замын урд, хойд талд нийт 2392 м² талбайд явган зам тавьж, голын тусгаарлах зурвасанд 3x0,8x1,5 харьцаатай 1400у/м газарт 468 ширхэг хайс суурилуулж, 24 у/м шат тавьж, автозамын 420ш бродюр шинээр суурилуулсан.

Нарны замын голын тусгаарлах зурвасд 7300ш 10 төрлийн нэг наст цэцэг тарилаа.

Нийтийн эзэмшлийн гудамж “ Нарны зам” –ын 153000 м² буюу 8.5 км замыг зам талбайн 15 үйлчлэгч, 1 мастертай өдөр бүр тогтмол цэвэрлэж, 562 удаагийн рейсээр 1000.6 тонн гарсан хог хаягдлыг хогийн цэг рүү тээвэрлэсэн байна.

Тус газар нь архивын баримт хадгалах өрөөг тохижуулан, 2006-2012 оны архивын баримтууд хадгалагдаж байна. Хадгаламжийн сангийн өрөө нь чийг, дулаан хэмжих багаж, үдэх машин, скайнер, өнгөт принтер, даацын тавиур зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр ханган ажиллаж байна. Хөтлөх хрэгийн нэрийн жагсаалтыг Нийслэлийн архивын газрын ББНШАЗК-ын хурлаар батлуулж, уг жагсаалтын дагуу алба нэгжүүдээс архивын баримтыг хүлээн авсан.

Нийслэлийн хот тохижилтын газар нь 90-ээд жилийн түүхтэй хэдий ч зохион байгуулалтын өөрчлөлтүүдээс болж архивын баримтуудаа тухай бүр Нийслэлийн архивын газарт өгч хөмрөг үүсгэн 1974-1993 оны баримтуудыг хадгалуулсан байдаг. 1995 онд Нийслэлийн захирагчийн ажлын алба байгуулагдсанаар Барилга хот тохижилтын газар нь уг албанд харьяалагдаж, архивын баримтууд нь тус газрын архивт хадгалагдаж байгаа болно.

Тус газрын архивт 2006-2012 нийтдээ 938 баримт байгаагаас

- байнга хадгалах 166 хадгаламжийн нэгж
- 70 жил хадгалах 31 хадгаламжийн нэгж
- түр хадгалах 580 хадгаламжийн нэгж
- хадгалах хугацаа дууссан 161 хадгаламжийн нэгжийг устгахаар акт үйлдэв.

2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 100 дугаар тогтоолоор Нийслэлийн хот тохижилтын газрыг татан буулгасантай холбогдуулж Нийслэлийн Архивын газарт тус газрын архивт хадгалагдаж байсан хадгаламжийн нэгжүүдийг шилжүүлэн өгөхөөр Нийслэлийн архивын газрын БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж, бүртгэлээ батлуулан байнга хадгалах 166 хадгаламжийн нэгж, тусгай төрлийн баримт болох 5 ширхэг альбомыг тус газарт хүлээлгэн өгсөн.

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ БИЧСЭН:
ДОТООД АЖЛЫН МЭРГЭЖИЛТЭН

Н.БАЙГАЛЬ